

Л. Норовсүрэн

ИРГЭНИЙ СЭТГҮҮЛ ЗҮЙН ОНОЛЫН ЗАРИМ АСУУДАЛД

*Хэзээ та иргэдтэй
харилцаж эхэлнэ. Тэд таныг
сэтгүүл зүйд цэцэн
мэргэнээр газарчилж өгнө.*

Женни Бакнер

Ерээд оны эхээр Монгол оронд өрнөсөн ардчилсан хувьсгал манай орны нийгэм, улс төр, эдийн засгийн амьдрал, оюуны салбарын бүхий л хүрээ, түүний дотор сэтгүүл зүйн үйл ажиллагаанд эргэлтийн шинжтэй өөрчлөлт гаргасан билээ. Энэ өөрчлөлтийн явцад мэдээллийн уламжлалт хэрэгслүүд хүрээгээ тэлж, сэтгүүл зүйн урьд өмнө сонсогдож байгаагүй шинэ хэлбэрүүдийн тухай ярьж бичих болсон. Үүний нэг нь иргэний сэтгүүл зүй юм.

Өнөөдөр бидэнд цоо шинэ зүйл мэт сонсогдож байгаа мэдээлэл солилцож дамжуулах өвөрмөц арга хэлбэр болох Иргэний сэтгүүл зүй нь Америкийн нийгэмд сүүлийн дөчөөд жилийн турш яригдаж ирсэн ойлголт бөгөөд өнгөрсөн зууны ерээд оноос сэтгүүл зүйн практикт хүчтэй нэвтэрч эхэлсэн юм.

Сэтгүүл зүйн шинэ төрлийг үүсгэн хөгжүүлэх шаардлага юунаас гарав? Америк орон ардчиллын өлгий нутаг гэдгийг хэн бүхэн мэднэ. Ардчилал хөгжихийн хэрээр иргэдийн чөлөөт байдал нэмэгдэж, улс орон хөгжихийн хэрээр ард түмний дийлэнх хэсгийн амьдрал сайжирсан нь хүмүүнлэг энэрэнгүй нийгмийн ололт мөн. Гэвч XX зууны сүүлийн хагасаас ардчилын эвэрэлт болж байгааг судлаачид ч, жирийн иргэдийн идэвхтэй хэсэг ч эмзэглэн бичиж, ярих болсон. Энэ нь юуны өмнө ахуй амьдралын боломждоо сэтгэл тайвширсан иргэд нийгэм-улс төрийн амьдралд оролцох, түүний төлөө санаа тавих нь эрс багассан явдлаар тайлбарлагдах юм. Ийм амарлингуй байдлын үр дагавар болж нийгэмд замбараагүй байдал газар авч хүчирхийлэл, аллага таллага, мансууруулах бодисын наймаа ба хэрэглээ зэрэг сэтгэл түгшээсэн гэмт хэргийн тоо нэмэгдэж, хүүхэд залуучуудын хүмүүжил доголдон, нийгмийн цөөнх болсон эмзэг бүлгийн амьдрал улам бүр доройтож, гэр оронгүй тэнүүлчид хэрэгт орооцолдох нь нэмэгдсэн зэрэг үзэгдлүүд ихэссэн байна.

Түүнчлэн иргэдийн дотор улс төрийн бодлогыг сонирхох хэмжээ буурч, улс нийгэм, оршин суугаа орчныхоо хөгжил цэцэглэлтэд санаа тавих нь багасч, товчоор хэлбэл нийгэм ихээхэн урсгал байдалтай болоход хүрчээ. Энэ мэт сөрөг үзэгдлүүд бас сэтгүүл зүйн үйл ажиллагааны доголдолтой ч холбоотой ажээ. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд дэлхий дахины болон өөрийн орны улс төрийн үйл явдал, нэр цуутай хүмүүсийг тойрсон адал явдлуудад гол анхаарлаа хандуулж, жирийн иргэдийн амьдралд хуримтлагдсан хурц

асуудлууд ямар нэг хэмжээгээр орхигдож ирсэн нь тодорхой юм. Энэ бүх байдлаас болж сэтгүүл зүйг жирийн иргэдийн амьдрал ахуйд ойртуулж, улам бүр олон нийтийн шинжтэй болгох шаардлага тулгарсан нь иргэний сэтгүүл зүй үүсэх шалтгаан болсон гэж судлаачид тэмдэглэж байна.

Иргэний сэтгүүл зүй нь нэг талаас хэвлэл мэдээллийн хэрэгслээс амьдралын гүн лүү тавих анхаарлаа нэмэгдүүлж, жирийн иргэдийн ахуй амьдралыг илүү тусгах үйл ажиллагаа, нөгөө талаас хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанд иргэдийг өргөнөөр татан оролцуулж тэднээс ахуй амьдралынхаа тулгамдсан асуудлыг сөхөн тавьж, шийдвэрлэхэд нь мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчид туслах явдал юм. Энэ утгаараа мэргэжлийн сэтгүүл зүй, олон нийтийн сэтгүүл зүйн зохистой хослол болон хөгжиж байна.

Энэ нь жам ёсны үйл явц ч байж болох юм. XIX зууны их сэтгэгч К.Маркс 1844 онд бичсэн «Эдийн засаг, философийн гар бичмэл» болон түүнтэй залгаагаар Ф.Энгельстэй хамтран бичсэн «Германы үзэл суртал» гэдэг зохиолууддаа хүний чөлөөт хөгжлийг хангаж, оюун ухааны өндөр түвшинд хүрсэн үед авьяас шаардсан мэргэжил, өөрөөр хэлбэл уран бүтээлийн зүйл нь соёлт иргэн бүрийн хийдэг ажил, хэрэглээ болж хувирна гэсэн санааг хэлсэн байдаг. Бас олон түмний санаа бодлыг тусгадаггүй, тэднийг оролцуулдаггүй хэвлэл зөвхөн агаарт дүүжлээстэй хэвээр хоцордог гэсэн үг ч байдаг.

Өнөөгийн Америк оронд хөгжиж байгаа жирийн иргэдийн сэтгүүл зүйн үйл ажиллагааг ажиглахад дээрх томъёоллууд эрхгүй санаанд орж байгаа юм.

Ерөөсөө Иргэний сэтгүүл зүй гэж юу вэ? хэрхэн үүсэв, яаж ажилладаг юм бэ? гэсэн асуудал бидэнд чухал юм.

Иргэний сэтгүүл зүй нь юуны өмнө амьдралдаа тохиолдсон чухал асуудлыг мэдээлэхэд идэвхтэй оролцдог сонгогчдын сэтгүүл зүйн үйл ажиллагаа юм. Энэ утгаар нь түүнийг олон нийтийн сэтгүүл зүй гэж нэрлэдэг ёс ч бий.

Олон нийтийн хэвлэлүүд, ялангуяа нийтлэлийн бодлогоороо олон нийттэй хүчтэй холбогддог сонинуудын үйл ажиллагаанд нийгмийн идэвхтэй хэсэг түлхүү оролцож иргэний чухал асуудлыг мэдээлэх болсноор иргэний сэтгүүл зүй үүссэн байна. Иргэний сэтгүүл зүй нь интерактив сэтгүүл зүйн нэг хэлбэр бөгөөд амьдралын өөр өөр түвшний хүмүүсийг сонин сэтгүүлд өгүүлэл материал бичүүлэх, амьдралаас олж илрүүлсэн зүйлээ мэдээлэхэд өргөнөөр татан оролцуулдаг сэтгүүл зүйн үйл ажиллагаа юм.

Америкийн сэтгүүлч эрдэмтэд иргэний сэтгүүл зүйн нийгэмд гүйцэтгэх үүргийг олонтаа тодорхойлсны дотор эрдэмтэн Гунаратне сэтгүүл зүйн энэ хэлбэрийн өөр өөр шинж чанарыг илтгэсэн гурван янзын тодорхойлолт гаргасан байна. Тэрбээр **нэгдүгээрт**: Энгийн иргэдийн дотроос идэвхтэй хэсгийг нэгтгэх замаар олон нийтийн ухамсарт хүч нэмж, зоригжуулахад сэтгүүл зүйг чиглүүлэх хөдөлгөөн мөн гэжээ. Энэ нь иргэний сэтгүүл зүй олон талтай болохыг харуулж байгаа юм. **Хоёрдугаарт**: Олон нийтийн анхаарал

татсан асуудлыг хэлэлцэхэд өөрийн ухамсраар оролцож дуу хоолойгоо илэрхийлэх идэвх бүхий олон нийтийг буй болгох хөдөлгөөн хэмээн тодорхойлжээ. **Гуравдугаарт:** Нэг талаас хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдээлэл түгээх үйл явцыг илүү эрчимтэй болгон олон нийтэд хүрч ажиллах, нөгөө талаас иргэд тулгарсан асуудлууддаа хэрхэн хандаж байгаа хийгээд түүнийг шийдвэрлэх арга замыг хэрхэн эрж хайж байгааг тодорхойлох оролдлого гэсэн байна.

Дурьдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд сонин сэтгүүл, мэдээллийн бусад хэрэгслүүд иргэний асуудлаар цуврал өгүүллүүд нийтэлж, түүндээ орон нутаг, тэндхийн хүмүүс, хэсэг бүлгүүдийн тулгамдсан асуудлыг сурвалжлан бичиж, шийдвэрлэх арга замыг санал болгодог юм. Иргэний сэтгүүл зүйн өөр нэг хэлбэр нь улс төрийн компанит ажил, эсвэл төсөв хэлэлцэх мэт шуугиантай том үйл явдлын үеэр цугларч өөр өөр ойлголттой хүмүүс үзэл бодлоо солилцдог иргэдийн төлөөлөгчдийн хурал юм. Хөгжил дэвшлийн төлөө, ардчиллыг эрүүлжүүлэхийн төлөө тэдний хийж буй ажил, гаргаж байгаа саналыг хэвлэл мэдээлэл дамжуулан цацдаг. Заримдаа улс орон даяар болж буй чухал үйл явдлын талаар олон нийтийн санал асуулга ч явуулдаг. Энэ арга ялангуяа тогтмол хэвлэлүүдэд уламжлал болсон юм. Түүнчлэн хэвлэлүүд өөр өөр бодолтой хүмүүсийг урьж ирүүлэн «Дугуй ширээний» ярилцлага хийж тэдний үзэл бодлын ялгааг тогтоох, зарим нийтлэг учир шалтгааныг илрүүлэх оролдлого хийж, түүнийгээ хэвлэлээр мэдээлдэг байна. Үнэнийг хэлэхэд энэ бүхэн манай хувьсгалт хэвлэлд хэрэглэж байсан арга туршлагыг санагдуулж байгаа юм.

Иргэний сэтгүүл зүй хөгжлийнхөө эхэн үед мэргэжлийн хүрээнийхний зарим хэсгийн эсэргүүцэлтэй тулгарч байсныг тэмдэглэвэл зохино. Тэд, иргэний сэтгүүл зүй нь нийгмийн хариуцлагын онолыг хэрэгжүүлэхийг оролддог хийгээд олон нийтийн харилцааны хатуу тогтсон хэлбэр болохыг нь онцлон харж байв. Энэ ойлголтын буруу болохыг олонх судлаач цохон заасан байдаг. Учир нь хэвлэл мэдээллийн орон нутгийн шинж чанарыг илүү үндэсний шинжтэй мэдээллийн хэрэгсэл болох телевиз, вэб хуудас мэттэй өрсөлдөх чадвартай болгох шаардлага тулгарч байгаа юм.

Иргэний сэтгүүл зүйг үл ойшоогчдын зарим нь мэргэжлийн сэтгүүл зүйд тавигддаг хатуу шаардлага нь иргэний сэтгүүл зүйн ач холбогдлыг багасгаж, иргэдийн идэвх сонирхол аяндаа буурна гэж үзэж байна. Эсэргүүцэгчдийн гурав дахь хэсэг иргэний сэтгүүл зүй нь маш тодорхой асуудлыг хэт дэврүүлэн хөөрөгддөг нь нэг ёсны завхрал мөн гэж үздэг. Ийм санааг судлаач Эффрон 1997 онд Дальтонд хэвлүүлсэн нэг сэдэвт бүтээлдээ хүчтэй илэрхийлсэн юм.

Энэ мэт үл ойшоох байдал, эрс эсэргүүцлийн аль алинтай тулгарсаар байгаа боловч иргэний сэтгүүл зүйн «туршилт» АНУ-ын иргэний сэтгүүл зүй урагш итгэлтэй замнаж, нийгмийн хариуцлагын онолыг хэрэгжүүлэх олон нийтийн хэрэгслийнхээ үүргийг хүлээсээр байна.

Иргэний сэтгүүл зүйг эсэргүүцэгчдийн дийлэнх хэсэг нь хэвлэл мэдээллийн зориудын хэрэгслийн мэргэшсэн үйл ажиллагааг мэргэжлийн бус хүмүүсийн гарт оруулснаар мэдээллийн үнэн бодитой байх зарчим алдагдана хэмээн болгоомжилж байлаа.

Ийм учраас ерээд оны эхний хагасаас идэвхтэй өрнөлтийн үе нь эхэлсэн иргэний сэтгүүл зүйг Америк орон даяар гол төлөв янз бүрийн чиглэлтэй төслүүдийн хэлбэрээр туршин хэрэгжүүлэх чиглэлийг түлхүү барьж эхэлсэн байна.

Энэхүү гарын авлагыг тэрлэгч миний хувьд 1999 онд АНУ-ын Нью Орлеан хотод болсон сэтгүүл зүйн багш нарын олон улсын чуулга уулзалтад оролцох завшаан олдсон юм. Нийтдээ 12 салбар хуралдаанаас бүтсэн энэ чуулга уулзалтад Иргэний сэтгүүл зүйн асуудал бие даасан салбар хуралдааны хэмжээнд яригдсан бөгөөд Америкийн сэтгүүлч, судлаач, багш нарын 49 хувь нь энэ шинэ салбарыг дэмжиж, цаг үеийн бодит шаардлагаар гарч ирсэн сэтгүүл зүйн үйл ажиллагааны нэг хэлбэр хэмээн хүлээн зөвшөөрсөн тухай мэдэгдэж байсан билээ.

Америкийн үндэсний бэлэг тэмдэг болсон ардчиллын зэврэлтийн эсрэг нигүүлсэнгүйн Пью сангийн санаачилга, дэмжлэгээр 1993 онд Иргэний сэтгүүл зүйн төвийг анх байгуулжээ. Тус төв урьд нь иймэрхүү чиглэлээр ажиллаж байсан Вичитагийн «Бүргэд», «Шарлотын ажиглагч» зэрэг туршилтын туршлагад тулгуурлан үйл ажиллагаагаа эхэлсэн байна. Гурван жилийн дараа буюу 1996 онд иргэний сэтгүүл зүй Америкийн нийгэмд газар авсан гажуудлыг засаж залруулахад ямар бодитой үр дүнд хүрч байгааг тандаж мэдэх зорилгоор иргэний сэтгүүл зүйн төслүүдэд хөндлөнгийн дүгнэлт хийлгүүлсэн юм.

Төслийг дүгнэгчид Америкийн янз бүрийн хрт тосгонд иргэний сэтгүүл зүй ямар янзтай байгааг төлөөлж чадах дөрвөн төсөл дээр төвлөрч судалгаагаа хийсэн юм. Судалгаанд Медисонд хэрэгжүүлсэн «Бид Висконсоны хүмүүс», Сан-Францискод хэрэгжүүлсэн «Сонгогчийн дуу хоолой», Бингхамтонд хэрэгжүүлсэн «Бидний ирээдүй», Шарлотод хэрэгжүүлсэн «Хөршийн холбоогоо сэргээе» гэсэн төслүүд хамрагдсан байна.

Төслийн үр дүнд хөндлөнгийн шинжээчид сэтгэл хангалуун байгаагаа өгүүлсэн нь зүй ёсны хэрэг байлаа. Зөвхөн Медисонд хэрэгжүүлсэн төслийн үр дүнд иргэдийн идэвх ухамсарт мэдэгдэхүйц ахиц гарсан дүн харагджээ. Тухайлбал төслийн дараа тэндхийн иргэдийн 40 хувь нь төслийг нэрээр нь мэддэг болж, 52 хувь нь улс төрийн хэрэгт иргэд идэвхтэй оролцохын ашиг тусыг ухаардаг болж, мөн тийм хувь нь амьдарч байгаа газраа илүү тохилог сайхан болгохыг удирдагчиддаа шаарддаг болж, 74 хувь нь нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд саналаа нэмэрлэдэг болж, 64 хувь нь энэ хэрэгт биеэр оролцдог болж, 60 хувь нь сонгуульд саналаа өгөх шаардлагыг гүнээ ухамсарладаг болсон байжээ. Үүнээс үндэслэн иргэний сэтгүүл зүйг

нөхцөл байдлыг хувирган өөрчлөгч, бодитой үр дүн гаргагч, нэг үгээр хэлбэл бүтээлч сэтгүүл зүй гэж үзэх үндэстэй юм.

Одоо Монголын уламжлалын талаар цухас дурьдая. Бидний хувьд Иргэний сэтгүүл зүй нь шинэ мөртлөө хуучин зүйл юм. Монголын сэтгүүл зүйн өнгөрсөн түүхийг мөшгөж үзвэл иргэний сэтгүүл зүйн уламжлал арвин байна. Иргэний сэтгүүл зүйг нэг талаас нь харвал олон нийт рүү хандсан мэдээллийн үйл ажиллагаа, нөгөө талаас нь харвал идэвхтэн бичигчдийн сэтгүүл зүй юм.

Эхний шинжийн хувьд бидэнд багагүй туршлага бий. Монголын хувьсгалт хэвлэл үүссэн цагаасаа эхлэн одон түмнийг сонин сэтгүүлийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулахыг эрмэлзэж, тэр ч байтугай бичиг мэдэхгүй хүмүүсийг хүртэл сонины ажилд туслуулахын тулд «Аман сурвалжлага»-ын аргыг хүртэл хэрэглэж байлаа. Иргэний сэтгүүл зүйн үйл ажиллагаа нь мэдээллийн хэрэгслийн зохион байгуулах үүргээр дамжин илэрдэг онцлогтой байна.

Манай хувьсгалт сэтгүүл зүйд хэрэгжүүлж байсан сонин хэвлэлийн олон нийтийн үндсийг бэхжүүлэхэд чиглэсэн олон хэлбэрийн ажилд иргэний сэтгүүл зүйн элемент агуулагдаж байсан гэж үзмээр байдаг. Мэдээллийн хэрэгслээс иргэдтэй харилцах харилцааны шууд холбооны хэлбэр болох уншигчдын бага хурал, нийгмийн судалгаа, иргэдийн захидал мэдээлэл нь сонин-уншигч хоёрыг ойртуулж, улмаар олон түмнийг мэдээллийн хэрэгслийн идэвхтэй оролцогч, иргэний сэтгүүлч болгох шилдэг арга болж байлаа. Манай хэвлэл мэдээллийн хэрэгслүүд редакцийн шуудан, хамтын үзлэг, сурвалжлага, дугуй ширээний яриа, шөвлэн авах, орон тооны бус хэлтэс, сурвалжлах хэсэг байгуулах, олон нийтийн хүлээн авах байр ажиллуулах зэрэг хэлбэрээр жирийн хөдөлмөрчдийг нийтлэл, нэвтрүүлгийн үйл ажиллагаанд татан оролцуулдаг байсан нь өнөөдөр Америк оронд хөгжиж байгаа иргэний сэтгүүл зүйн аргуудтай адилхан юм.

Манай оронд өрнөсөн ардчилсан хувьсгалын жилүүдэд сэтгүүл зүйн нийгмийн үүрэг, үйл ажиллагааны зарчим, арга хэлбэр үндсээрээ өөрчлөгдөж, төр засгийн үйл ажиллагаанд тавих олон нийтийн хяналтын хэрэгсэл болох тийш замнаж байгаа хэдий ч гол төлөв сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудын мэдлэг мэргэжил дутмаг, ёс зүйн хэм хэмжээг үл сахиснаас үүдэлтэй олон гажуудал гарч байгаа нь нууц биш юм. Үүний нэг нь хэвлэл мэдээллийн хэрэгсэлд жирийн иргэдийн дуу хоолой бараг сонсогдохоо больсон явдал юм. Үүнд хоёр шалтгаан бий. Манай өдөр тутмын томоохон сонин, радио, телевизүүд сэтгүүлч, сурвалжлагчдад хийсний хэрээр хөлс олгох нэрийдлээр мэдээний уралдаанд гүйлгэдэг болсноос идэвхтний материал шахагдах болсон. Чөлөөт нэртэй хувийн сонинууд зах зээл олж авах шалтгаанаар цөөн ажилтнаа хов жив, адал балмад явдлаар хөөцөлдүүлдэг болсон бөгөөд эдгээр сонинуудад үнэн хэрэгтээ олон түмний дуу хоолой хаалттай байдаг.

Нөгөө нэг шалтгаан нь зовж зүдэрсэн эгэл борчуудын амьдралыг тусгаж, тэдэнд тохиолдсон бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэхэд хэвлэл мэдээлэл

хүйтэн хөндий хандах болсон явдал юм. Ардчиллыг зөв гольдролд оруулж, нийгмийг эрүүлжүүлэхэд шаардлагатай олон сэдэв үнэн хэрэгтээ хэвлэл мэдээллийн гадна үлдэж байна. Нийгэмд хуримтлагдсан хурц асуудал болох гэмт хэргийн өсөлт, ядуурал, оюуны хоосрол, янхандалт, хувиа хичээх үзэл, архидан согтуурах дон, траншейны хүүхэд гэх мэт иргэд, хууль хяналтын байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгслийн хамтын чармайлтаар шийдвэрлэх асуудал олон байна.

Энэ бүхэн нь манай оронд иргэний сэтгүүл зүйг эрчимтэй хөгжүүлэх, энэ асуудлаар дагнан бичдэг хэвлэл буй болгох шаардлагыг зүй ёсоор төрүүлж байгаа юм.

Иргэний сэтгүүл зүйн уламжлалын асуудлыг авч үзэхдээ утга зохиолын сан хөмрөг доторх жирийн ардын эрх ашгийг хамгаалах санаа шингэсэн бүтээлүүдийг эрж шүүрдэхээс эхлэх шаардлагатай болдог. Ингэж үзвэл бидний өвөг дээдэс арвин туршлагыг үлдээжээ.

Монголын утга зохиол дахь иргэний сэдэв хэдийгээр урсгал шинжтэй ч гэсэн эртний уламжлалтай. Ялангуяа XVIII-XIX зууны үе онцгой анхаарал татаж байгаа юм. Монголын нийтлэл нь хуучин уран зохиолын гүнд аажмаар үүсэн бүрэлдсэн бөгөөд XIX зууныг хүртэл аман болон бичгийн зохиолын шууд нөлөөний дор түүний нэг бүрэлдэхүүн хэсэг болж иржээ. Харин XIX зууны Монгол оронд тохиолдсон нийгэм-улс төрийн хурц тохироо нь утга зохиолыг цаг үеэ шуурхай тусгадаг, нийгмийн сөрөг үзэгдэлд шүүмжлэл дүгнэлттэй ханддаг болгохыг шаардсан нь их утга зохиол, түүний дотор уран зохиолоос нийтлэлийн шинж ялгаран гарах шалтгаан болсон билээ. Энэ үеийн нийтлэл-зохиолын дотор эгэл ардын эрх ашгийг хамгаалсан, санаа зоригийг илэрхийлсэн бүтээл арвин байдаг.

XIX зууны Монголын бичгийн мэргэд, тэдний дотроос В.Инжиннаши, Л.Агваанхайдав, З.Агваанбалдан, Д.Равжаа нар иргэний нийтлэлийн үнэтэй өвийг үлдээсэн юм. Амьдарч ахуй цагийнх нь нийгэм-улс төрийн хямрал тэмцэл, Манжийн түрэмгийлэгчдээс явуулж байсан харгис бодлого зэрэг нь тэдний үзэл ухамсар төлөвшихөд ихээхэн нөлөөлжээ. Ард нийтийн амьдрал өдрөөс өдөрт бууран доройтож, харанхуй бүдүүлгийн туйлд хүрээд байхад түмний тусыг огоорон хувийн жаргалыг бодож, харийнханд найр тавин бөхөлзөгч ноёдыг хараад тэд өөрийн эрхгүй үзэн ядаж, тэрхүү эсэргүүцлээ үзэг цаас нийлүүлэн илэрхийлэхээс өөр аргагүйд хүрдэг байжээ.

XIX зууны Монголын нийгмийн өмнө тулгарч байсан хурц асуудлын нэг бол гадаад дотоодын дарлалд нэрвэгдсэн ард иргэд ертөнцийн соёл боловсролоос ихээхэн хоцорч, улс төрийн бодлогоос нэн хөндий байсан явдал мөн. В. Инжиннаши энэ харанхуй бүдүүлэг амьдралын гол шалтгааныг манжийн ноёрхлын уршиг гэж заагаад үндэсний соёл боловсролоо хөгжүүлэхийг ард түмэндээ уриалж байлаа. Тухайлбал, «Хөх судар» романы оршил болох «Товчит толт»-д бичихдээ «Их буянтай их хүчтэн өдөр бүр зүв

зүгээр жарган, наран сарыг өнгөрүүлж, сайн болвоос дал наян жил амьдраад, эцэст нь нэгэн өглөөний зуур үхэж эчсэний хойно хүжийн утаа сарнисан мэт ялиг далиг мөр сүүдэргүй болж эчээд, цаг эцэстэл нэгхэн ч хүн мэдэхгүй болгон эчихийг эргүүлэн бодвоос мөн баахан бичиг сударт нэр хоцруулан түмэн үед мэдэлт ардад дурьдагдан, хүсэн хэлэлцэгдсүгэй хэмээн санавал бололтой» гэжээ.

Монголын бичгийн их хүн 3.Агваанбалдан оршин байгаа нийгэм, цаг үеийнхээ байдлыг эргэцүүлж бичсэн төрөгдлийн элемент бүхий олон бүтээл туурвисны нэлээд нь иргэний нийтлэлийн шинжийг агуулж байлаа. Тэдгээр бүтээлээс эх орон, ард түмнээ хайрлан үздэг, үндэсний баялгаа хөгжүүлэх, ард олноо соён гэгээрүүлэхийн төлөө санаа тавьдаг эх орончийн зүрхний өчил мэдрэгдэж байдаг юм. Тэрээр газар тариалан, мал аж ахуй, худалдаа арилжаа, бичиг үсэг, тоо бодлогод ард иргэдийг сургахыг уриалж, хур бороо орж, авс ногоо ургах зэрэг сайхан учралыг хүсч, өвчин тахал, цэрэг дайны аюул, байгалийн гамшиг, өлсгөлөн гуйланчлал бүү гараасай хэмээн ерөөл хүртэл тавьж байжээ.

3.Агваанбалдан ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө үзэл санааг дэмжиж, манжийн эзэрхийллийг эсэргүүцдэг, улмаар манж хятадын түрэмгийлэгчидтэй хуйвалдсан Монголын баяд ноёд, дээд лам нарыг эсэргүүцэн, харийн дарлалаас гарахын тулд ард түмэн шашны талаар ч, улс төрийн талаар ч нягтарахын чухлыг эрхэмлэн сурталчилж байсан нь яриангүй иргэний нийтлэл байжээ.

Монголын иргэний нийтлэл «Үг» зохиолын хэлбэрээр зонхилон гарч байсан нэг онцлог бий. Үүний томоохон төлөөлөгчийн нэг нь Л.Агваанхайдав байв. Тэрбээр энгийн нэг номч бясалгагч бус, цаг үеэ гойд мэдэрч шүүмжлэлтэй ханддаг, хүн ардын ирээдүйн сайн сайхны төлөө сэтгэл зовнин шударга үнэн үгээ ил шууд хэлдэг илчлэн шүүмжлэгч-нийтлэлч байжээ.

Л.Агваанхайдав «Хурмастын тахилга» гэдэг төрөгдөлдөө төр, шашны толгойлогчдын бурангуй явдлаас болж жирийн иргэд тэсвэрлэшгүй их зовж зүдэрч байгаад харамсаад барахгүйн эрхээр тэрхүү хар нүглийг арилгаж өгөхийг хурмаст тэнгэрт даатгаж бичсэн бол «Үхэр, хонь, ямаа гурвын яриа» гэдэг үг зохиолдоо нэг талаас гаднаа энэрэн нигүүлсэгчийн дүр эсгэж, дотроо авах идэхийн шуналд автсан ихэс лам нар, нөгөө талаас дарлагдан зовсон эрх мэдэлгүй ардын дүрийг адгуус амьтдаар төлөөлүүлж үзүүлсэн байдаг. Дээрх хоёр бүтээлийн аль алинд иргэний хурц асуудлыг хөндсөн гэж хэлж болно.

Монголын иргэний нийтлэл нь **нэгдүгээрт**: Бичгийн мэргэдээс иргэний асуудлыг хөндөж бичсэн бүтээл, **хоёрдугаарт**: иргэдээс өөрсдийн амьдрал ахуйд тохиолдсон хүнд бэрх асуудлыг эрх бүхий газар, хүмүүст сонордуулж, заалдан тэмцсэн бичиг зохиол гэсэн хэлбэртэй байжээ. Хоёрдахь хэлбэрийн бүтээлийн тодорхой жишээ нь ардын заргын бичгүүд мөн. Заргын бичиг нь

иргэдээс шударга ёсыг тогтоох, амьдрал ахуйгаа сайжруулах, эрх ашгаа хамгаалахын төлөө хийсэн тэмцлийн хэлбэр байв.

Ардын заргын бичгүүд нь жирийн ард иргэдээс нийгмийн шударга бус явдлыг илчлэн шүүмжлэх, улмаар засч залруулах санаа агуулсан байдгаараа иргэний нийтлэлийн шинжийг агуулж байсан юм. Заргын бичгүүд нь:

1. Юуны өмнө жирийн иргэдийн доторх тэргүүний хэсгийнхний үзэл санаа, идэвхтэй байр суурь илрэн гарч байгаа,

2. Нийгмийн удирдлагын систем дэх гажуудлыг иргэний зориг гарган сөхөж тавьсан илчлэн шүүмжлэх чиглэлтэй,

3. Нийгэм олны хийгээд өөрийн эрх ашгийн төлөө нэгэн биедээ ирэх зэмлэлээс үл эмээн эрх бүхий байгууллага, хүмүүстэй заалдан тэмцсэн шинжтэй,

4. Өгүүлэх арга маяг, бүтэц, хэл найруулгын хувьд сонин сэтгүүлийн бичлэгтэй үлэмж төстэй,

5. Тухайн нийгэм улс төр, аж байдлын шууд тусгал болж, чухал баримт мэдээлэл агуулсан байдаг,

Эцэст нь ард түмний аж байдлын мэдээг төр засгийн зохих шатны удирдлагад хүргэж засч сайжруулахад чиглэсэн олон нийтийн хаяналтын шинжтэй бөгөөд төр-иргэдийн хооронд мэдээллийн эргэх холбоо үүсгэж байсан зэрэг шинжээрээ орчин үеийн иргэний сэтгүүл зүйн элементийг агуулж байжээ.

Ерөөсөө иргэний сэтгүүл зүйн анхны үр хөврөл бичиг үсэг үүссэн үеэс бүрэлдсэн гэж үзэх үндэс ч бий. Бичиг үсэг үүссэнээр иргэний мэдээлэл солилцох өргөн боломж нээгдсэн бөгөөд үүний нэг уламжлалт хэлбэр нь захидал юм. Захидал нь эрт цагаас нааш мэдээлэл солилцох өвөрмөц хэрэгсэл, суваг болж иржээ. Учир нь захидал өөрөө мэдээлэл агуулагч, бас түүнийг зөөгч юм. Нөгөө талаар захидал нь хүний бодол санаа, сэтгэлийн хөдлөлийн нарийн мэдрэмжийг агуулсан өвөрмөц нийтлэл мөн. Захидал авсан хүн ертөнцийн нөгөө талд байгаа эцэг эх, төрөл төрөгсдийнхөө хэрхэн аж төрж байгааг нэгд нэгэнгүй мэдэхийн хамт, нийгэм-улс төрийн үйл явдал, хүн ардын аж амьдрал, цаг агаарын байдал зэргийн талаар шинэ сэргэг мэдээлэл авч байдаг. Түүнчлэн захидал дотор нийгмийн идэвхтэй, боловсролтой хэсэг цаг үеэ шинжлэн дүгнэсэн, улс төрийн асуудлаар санал онолоо солилцсон ажил хэрэгч, иргэнлэг санаа ч агуулагдаж байдаг. Үүнийг манай гаригийн их сэтгэгчид, бичгийн мэргэд улс төр гүн ухааны үзлээ захидлын хэлбэрээр гаргаж тавьсан олон баримтууд нотолж байгаа юм.

Монгол дахь иргэний сэтгүүл зүйн уламжлал нь бүр сэтгүүл зүйн өмнөх үзэгдлүүдийн үеэс улбаатай гэж хэлж болно. Оршин буй нийгэм цаг үеийн байдалд шуурхай дүн шинжилгээ хийж, түүний хөгжилд бодитой нөлөөлөхийг эрмэлзсэн, тогтмол хэвлэл гарахаас өмнөх үеийн аман ба бичгийн утга зохиолын чиглэлийг бид сэтгүүл зүйн өмнөх үзэгдэл хэмээн томъёолдог. Өөрөөр хэлбэл, сэтгүүл зүйн өнөөгийн үйл ажиллагааны элемент эрт үеийн

утга зохиолд байсан эсэхийг шүүн тунгааж, шинэ соёлд хэрэглэнэ гэсэн хэрэг. Ийм шинжийнх нь хувьд авч үзвэл монголчуудын аман нийтлэлийн зүйлүүд бүхэлдээ иргэний сэтгүүл зүйн маягтай байсан гэж үзэхэд хүргэдэг.

Манай ард түмэн хот суурин газраас алба амины ажлаар ирсэн зочин гийчин, алсын аян жингээс буусан нутаг нэгтэн хэнийг ч болов тосон угтаж гэр хотол, айл саахалтаараа нэгэн гэртээ цуглан, хол ойрын сонин дуулж, шөнө дөл болтол ярилцдаг нь нүүдлийн соёл иргэншилт ард түмний аж төрөх өвөрмөц ёс, амьдрал ахуйд ашигтай шинэ сонин мэдээлэл олж авах арга юм. Ийнхүү аяндаа зохион байгууллагддаг мэдээлэл солилцох үйл явц нийгмийн хэсэг бүлгийн харилцаанд аажмаар хэвшин тогтож, тийм яриа таниулгыг ур чадвартай хийдэг бөгөөд байнгын арвин мэдээлэлтэй байдаг хүмүүс ялгаран гарсан нь бидний ойлгож байгаагаар аман нийтлэлч юм. Тэд амьдралын туршлага, бусдаас сонссон мэдээллээ хураан боловсруулж, тодорхой сэдэв чиглэл, илэрхийлэх аргатай аман нийтлэлүүдийг буй болгож, улмаар өөрсдөө мэргэжлийн аман нийтлэлчийн шинжийг олсон байдаг. Аман нийтлэлийн дотор ард түмний зан заншил, иргэдийн амьдрал ахуйн хүчирдэл, түүнд нөлөөлж байгаа хүчин зүйл, нийгмийн ёс суртахуунд харш үзэгдэл зэргийг хууч ярианы хэлбэрээр сөхөж тавьсан байдгаараа иргэний сэтгүүл зүйн шинжийг агуулсан байлаа. Түүнчлэн иргэд хоорондын мэдээлэл солилцох, санал бодлоо хуваалцах хэлбэр болж байснаараа орчин үеийн иргэний сэтгүүл зүйн арга хэлбэр болох иргэдийн хурал, олон нийтийн хэлэлцүүлгийн шинж төрхийг хадгалж байсан юм.

Аман нийтлэлийн уламжлал бодит сэтгүүл зүй үүссэний дараах үед ч мэдээлэл дамжуулах арга хэрэгсэл болсоор иржээ. Үндэсний ардчилсан хувьсгал ялснаар ард олон бичиг үсэгт суралцах явдал нэмэгдсэн нь сонин хэвлэлийн газрын түшиг тулгуур болсон идэвхтэн бичигчдийн хөдөлгөөн өрнүүлэх хөрс суурь болсон байна. Тухайн цаг үеийн байдалд уялдуулан сонин хэвлэлийн газрууд бичиг мэдэхгүй хүмүүсийг ч өөрийн ажилд татан оруулах зорилгоор «аман сурвалжлага»-ын аргыг өргөн хэрэглэж байв. Энэ нь иргэд санаж бодсон зүйл, олж сонссон мэдээллээ сонины газарт амаар хэлж бичүүлэх арга юм. Үнэн чанартаа урьдын аман нийлэлч нарын нэлээд нь сонин хэвлэлийн идэвхтэн бичигч, аман сурвалжлагч болцгоосон хэрэг.

Хувьсгалт хэвлэл дэх туршлага

Хувьсгалын эхэн үеийн хэвлэлүүдэд иргэний сэдвээр бичсэн нийтлэл арвин гарч байв. «Ардын эрх» сонинд гарч байсан «Эрдмийг бадруулъя», «Хувилгаан хэмээсэн нь чөтгөр болжээ» гэх мэт олон өгүүлэлд иргэдийг бичиг үсэгт сурган гэгээрүүлж, улмаар нийгэм-улс төрийн амьдралд идэвхтэй оролцдог болгох, учир мэдэхгүйн эрхээр дарлагдан зүдэрсэн номхон ардын эрх ашгийг хамгаалах санааг тодорхой илэрхийлсэн байдаг.

Энэ мэт зүйлс нь сонин хэвлэлийн газраас явуулах иргэний сэтгүүл зүйн үйл ажиллагааны хэлбэр болж байв. «Үнэн» сонины газраас 1929 оны 9 дүгээр сард гаргасан «Хот, хөдөөгийн сонинд бичигчдийн тусад зориулав» гэдэг товхимол нь иргэдийг олон түмний мэдээллийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах санааны илрэл болсон юм. Уг товхимолд «"Үнэн" хэмээх сонин бичгийн хороо болон ханын сониныг эрхлэх газарт тус тус сайн дурын үүднээс идэвхлэн оролцож захидал бичгээр буюу амаар мэдүүлэн ирэгсдийг сонинд бичигчид гэвэл зохино. Сонинд бичигчид нь ямар нэг албан тушаалыг жинхэнэ хүлээн авсан нь бус бөгөөд ямагт жинхэнэ ардын хувьсгалын тусад өөрийн идэвх хичээлээр оролцон явах тул тусгай үнэмлэх бичиг буюу тэмдгийг биедээ үл авна. Сонинд бичигчдээс мэдээлсэн оmtгой ташаагүй үнэн зүйлийг мушгихаар эсэргүүцэл гаргахыг урьдаас сэрэмжлэн сэргийлэхийн тулд сонинд бичигчид нь тус тус өөрийн дураар нууц нэрийг олж, ханын сонин болон төвийн сонины хооронд илгээсэн захидал мэдээний хойно тус тус тавьж, сүүлд нь жинхэнэ өөрийн нэр, гарын үсгийг зурж батална» гээд сонинд бичигчдийн үүрэг зорилт, ажлын арга барилыг тодорхой өгүүлсний зэрэгцээ сонинд бичигчдийн бүлгэмийг хэрхэн байгуулах, бүлгэмийн ажилд юуг тунхаглах, юунд анхаарах ёстойг зааж, бичлэгийн зарим төрөл, зүйлийн ялгаа, мөн чанар юунд оршихыг тайлбарласан байдаг. Энэ нь хэвлэл мэдээллийн ажлыг өрнүүлэхэд хэвлэл, олон түмний холбоог бэхжүүлэх явдал чухал гэдгийг тухайн үеийн сэтгүүлчид сайн ойлгож байсны баримт юм.

Иргэний сэтгүүл зүйг өргөн утгаар нь иргэд, олон нийтээс сэтгүүл зүйн үйл ажиллагаанд оролцох явдал хэмээн тодорхойлж болно. Монголын хувьсгалт хэвлэл түүхэн хөгжлийнхээ бүхий л үед энэ асуудалд анхаарч ирсэн байна. 1931 онд Ардын хувьсгалын 10 жилийн ойгоор, 1963 онд Монголын сэтгүүлчдийн анхдугаар их хурлын үеэр идэвхтэй бичигчдийн улсын зөвлөлгөөнийг тус тус хийж, ард иргэдийг сонин хэвлэлийн ажилд татан оролцуулах, тэдний дуу хоолойг мэдээллийн хэрэгслээр дамжуулан илэрхийлэх ажлын арга барилыг хэлэлцэн боловсруулсан нь манай хэвлэлээс олон түмэнтэй ойр дөт хамтран ажиллах бодлогын илэрхийлэл, иргэний сэтгүүл зүй манай оронд багагүй уламжлалтайн жишээ юм.

Манай орны хувьд иргэний сэтгүүл зүй нь хэвлэл мэдээллийн олон нийтийн үндсийг бэхжүүлэх зорилтын хүрээнд түүнийг хэрэгжүүлэх ажлын арга хэлбэр болон хөгжиж иржээ. Олон нийтийн үндсийг бэхжүүлэх зорилт нь **нэгдүгээрт**: уншигч сонсогчдыг хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанд татан оролцуулж тэдний дундаас ажилчин малчны сурвалжлагчдыг олноор тодруулан гаргах, **хоёрдугаарт**: сонин хэвлэлийн газраас хөдөлмөрчдийн дунд зохиох олон түмний ажлыг үр ашигтай өрнүүлэх үндсэн хоёр хэлбэрээр хэрэгжиж ирсэн байна. Иргэд, хөдөлмөрчдийн эрх ашгийг хамгаалдаг, энэ талаар төр засгийн явуулж байгаа бодлогод шүүмжлэл, дүгнэлттэй ханддаг хэвлэл бүхэн олон нийтийн идэвх хөдөлгөөнд түшиглэдэг байх учиртай.

Ингэхгүйгээр олон түмэн юу бодож, юу хүсч, юуг эсэргүүцэж байгааг мэдэх бодит бололцоогүй болно. Ийм бололцоог бүрдүүлэгч, сонин хэвлэлийн газрын нүд чих, дуу хоолой бол ажилчин малчны сурвалжлагчид юм.

Монголын хувьсгалт хэвлэл ажилчин малчны сурвалжлагчдаар өөрийгөө хүрээлүүлж тэдний хүчийг оновчтой ашиглах арвин туршлага хуримтлуулсан билээ. Наяад онд ЗХУ-ын 6 сая, манай оронд 15 мянга орчим идэвхтэн сурвалжлагч сонин хэвлэлийн ажилд тусалж, мэдээ сурвалжлага нийтлүүлдэг байв. Тэд амьдралын гүнд аж төрж, жирийн олон нийттэй өдөр тутмын харилцаатай байдаг учраас бичиж мэдээлсэн зүйлээс нь хөдөлмөр тэмцлийн жинхэнэ амт мэдрэгдэж, олон нийтийн санаа бодол, хүсэл зориг илэрч байдаг юм. Ийм үнэ цэнтэй мэдээллээр сонины амьд ажиллагааг хангаж байдаг учраас тэднийг сонин хэвлэлийн газрын түшиг тулгуур гэж нэрлэдэг.

Идэвхтэн сурвалжлагчдын хөдөлгөөний өрнөлтийн үр дүнд хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагаанд туслах ажил зохион байгуулалтын хувьд бэхжсэн юм. Үүний жишээ нь ажилчин-малчны сурвалжлах хэсэг мөн. Идэвхтэн бичигчдийг хэвлэл мэдээллийн нийтлэлд жигд тогтмол оролцуулахын тулд сурвалжлах хэсгийг байгуулдаг байв. Хэсгийг гол төлөв сум, сангийн аж ахуй, томоохон үйлдвэр, соёлын газрын дэргэд ажиллуулж сонины газар, намын анхан шатны байгууллага хоёр талаас нь дэмжиж тусалдаг байлаа.

Сурвалжлах хэсэг нь ажлын амжилт ололтыг түргэн шуурхай мэдээлэх, дутагдал доголдлыг газар авахуулалгүй засч залруулахад тусалдаг мэдээллийн нэг суваг болж байв. Төв, орон нутгийн аль ч сонинд «Идэвхтний мэдээ», «Орон нутгаас мэдээлсэн нь», «Сүүлчийн шуудангаас», «Газар газраас» гэх мэт тусгай булан хөтөлж, түүндээ идэвхтэн сурвалжлагчдын мэдээг багцлан нийтэлдэг байлаа.

Сурвалжлах хэсэг сонинд бичиж мэдээлэхийн зэрэгцээгээр хэвлэл сурталчлах, үдэшлэг уулзалт зохиох, үзэсгэлэн самбар гаргах, хэвлэл захиалуулах, хүргэх, тараахад нь хяналт тавих, нийтлэл нэвтрүүлгийн мөрөөр ажиллах, хамтран сурвалжлах зэрэг олон хэлбэрийн ажил зохиодог. Энэ бүхнээс үзэхэд сурвалжлах хэсэг нь иргэд, олон нийтээс сэтгүүл зүйн ажилд оролцох зохион байгуулалттай үйл ажиллагаа мөн гэж хэлж болно.

Үүнээс гадна манай сэтгүүл зүйд иргэдээс оролцох нэг хэлбэр нь хамтран сурвалжлах бригад байв. Тавь, жараад онд нэлээд дэлгэрсэн энэ хэлбэр нь янз бүрийн ажил мэргэжлийн идэвхтэнийг оролцуулж нийгмийн анхаарал төвлөрсөн асуудал, цаг үеийн кампанит ажлыг сурвалжлуулах аргаар илэрдэг. Тухайн үед Зөвлөлтийн хэвлэлээс зохион байгуулдаг байсан «Рейд»-ийг ийнхүү авч хэрэглэсэн бөгөөд олон хүний санаа бодол оролцдог учраас асуудлыг үнэлж цэгнэх, шинэлэг санаа дэвшүүлэх талаараа давуу талтай юм. Хамтран сурвалжлах бригад нь зөвхөн идэвхтэний санал санаачилгаар хийгдэх учиртай байтал манай сонинууд түүнд хөндлөнгөөс оролцож, бас дээр нь хяналт шалгалтын байгууллагын төлөөлөгчийг нэмж, албархуу шинжтэй

болгодог байлаа. Рейд нь зөвхөн дутагдлыг илрүүлдэг биш, бас чухал асуудлыг хөндөх, дотоод нөөц бололцоог илрүүлэх зэрэг зорилт агуулж болох бөгөөд мэдээллийн аль ч хэрэгслийн зүгээс зохион байгуулж болдог ажил юм. Хамгийн чухал нь зорилго, сэдэв, объект, бүрэлдэхүүнээ сонгох шаардлагатай байдаг. Сонин хэвлэлийн газар хаана юунд идэвхтэнээр үзлэг хийлгүүлэх саналаа хэлж, уг материалыг хүндтэй байранд тод томруун нийтлэх үүрэг хүлээдэг. Энэ утгаараа мэдээллийн хэрэгслийг идэвхтэнд ашиглуулах арга, иргэний сэтгүүл зүй явуулах нэг хэлбэр болдог ажээ.

Иргэний сэтгүүл зүйн үндсэн арга болох «Дугуй ширээний яриа»-г манай хэвлэлүүд өргөн хэрэглэдэг. Энэ нь уншигчдыг сонины нийтлэлийн ажилд татан оролцуулах зохистой хэлбэрийн нэг юм. Дугуй ширээний яриаг гол төлөв тодорхой хугацааны ажлын дүнг хэлэлцэх, эсвэл нийгмийн анхаарал татсан асуудлаар нэгдсэн байр суурьтай болох зорилгоор хийдэг. Ярианд тухайн асуудалд шууд холбоотой удирдах болон мэргэжлийн хүмүүс, иргэдийн төлөөлөгч оролцож болдог. Ярианы явцад гарсан дүгнэлтийг сонины газар нарийвчлан боловсруулж нийтлэх төдийгүй, цаашид асуудал болгож тавьдаг. Эцэст нь дугуй ширээний яриа нь уншигч олны санаа бодлыг сонсох, түүнийг мэдээлэх зохимжтой хэлбэр юм.

Идэвхтэн бичигчдийн дунд шилдэг бичлэгийн уралдаан зарлаж дүгнэх арга манай хэвлэлд уламжлал болсон юм. Энэ нь бас л иргэний сэтгүүл зүйн ажлын хэлбэр төдийгүй АНУ-д нийгмийн аль нэг тодорхой асуудлаар идэвхтэний цуврал өгүүлэл нийтэлдэгтэй адил юм.

Уралдааныг янз бүрийн сэдэв, бичлэгийн олон төрлөөр зарлаж, идэвхтэн бичигчдийг аль болох өргөн оролцуулах, сэдвийн хүрээг тэлэх, шударга зөв дүгнэх асуудал анхаарлын төвд байх ёстой. Уралдаан нь идэвхтэний ур чадварыг ахиулах, жирийн иргэдийг сонины ажилд шууд оролцуулах оновчтой аргын нэг юм.

Манай тогтмол хэвлэлд өргөн дэлгэрсэн «Шефлэн авах» арга нь орчин үеийн Америкийн иргэний сэтгүүл зүйн түгээмэл аргын нэг юм. Манай оронд гол төлөв ажил төрлөөрөө хоцорч доголдсон үйлдвэр, албан газар, сум, сангийн аж ахуйг сонины газар шефлэн авч тэнд хөдөлмөрийн идэвхийг өрнүүлэх олон хэлбэрийн ажил зохиож, дүн тоймыг сониндоо нийтэлдэг байв. Харин АНУ-д иргэний амьдрал ахуй, нийгмийн дэг журам, ёс зүйд харишилсан ноцтой асуудлыг иргэний сэтгүүлчид сонгон авч, асуудал болсон газарт урт богино хугацаагаар ажиллан, тодорхой үр дүнд хүрдэг байна.

Америкийн иргэний сэтгүүл зүйн нэг арга нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл, эсвэл иргэний сэтгүүл зүйн төсөл хэрэгжүүлж байгаа ажлын хэсгийн мэдэлд «Иргэдийг хүлээн авах» уулзалтын байр ажиллуулж тэнд иргэдийн мэдээлэл, санал гомдол, эрэлт хүсэлт зэрэгтэй байнга танилцдаг явдал юм.

Манай сонин хэвлэлийн газрууд «Олон нийтийн хүлээн авах байр» гаргаж дээрхтэй төстэй үйл ажиллагаа явуулдаг байв. Мөн сонгуулийн

сурталчилгааны үед иргэдтэй байнга уулзах байр, хэсэг ажилладаг нь бас л иргэний сэтгүүл зүйн арга хэлбэр юм. Учир нь иргэний сэтгүүл зүйн үйл ажиллагааны нэлээд хэсэг нь нийтлэл нэвтрүүлгийн хэлбэрээр биш, иргэдийн хурал, уулзалт, маргаан, мэтгэлцээн, санал солилцох ажлын хүрээнд хэрэгждэг. Тэдгээрээс гарсан онцын шаардлагатай санаа, дүгнэлт, шийдвэрийг хэвлэлд мэдээлдэг юм.

Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд олон түмний санаа бодол, эрэлт хэрэгцээг хэдийчинээ сайн ойлгож мэдэх тутам нийтлэлээ тэдний ашиг сонирхолд нийцүүлж чаддаг нь тодорхой. Үүний тулд хэвлэл мэдээллийн газрууд уншигчдийн дунд социологийн судалгааг байнга явуулж байх нь чухал юм. Манай хэвлэлүүдэд уншигчдын дунд анкет тараах, сонин сэтгүүлдээ тодорхой асуулт нийтэлж хариуг авах, эсвэл эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтарсан социологийн судалгаа явуулах арга уламжлал болсон юм. Социологийн судалгаа нь хүн хүч, хөрөнгө зардал шаардсан нарийн ажил байдаг. Гэвч түүнийг үнэн зөв хийсний үр дүн их юм. Харамсалтай нь өнөөдөр манай тогтмол хэвлэл, мэдээллийн бусад хэрэгсэл, мэргэжлийн зарим байгууллагаас хийж байгаа судалгаа нь сэтгүүл зүйн гол гогцоо асуудлыг хангалтгүй тусгасан, газар нутаг, хүн ам, нийгмийн бүтцийн төлөөллийг бүрэн илэрхийлж чадахгүй байх нь олонтаа үзэгдэж байна.

Иргэд, олон нийтээс сэтгүүл зүйн үйл хэрэгт оролцох нэг хэлбэр нь хөдөлмөрчдийн захидал мөн. Манай тогтмол хэвлэлүүд хөдөлмөрчдийн захидлыг «Редакцийн шуудан», «Уншигчдийн захидлаас» зэрэг буланд төрөлжүүлэн нийтэлж, заримыг холбогдох эрх бүхий байгууллагад шилжүүлж, мөн «Нийтлэгдээгүй захидлын мөрөөр» сурвалжлан бичдэг туршлагыг буй болгосон юм.

Хөдөлмөрчдийн захидал нь нийтлэлийн бусад хэлбэрээс үлэмж онцлогтой. Учир нь хүмүүс хэний ч шахалт шаардлагагүйгээр санасан бодсоноо чөлөөтэй илэрхийлдэг, бичих зүйлийн сэдэв нь өргөн дэлгэр байдаг. Хөдөлмөрчдөөс шуудангаар ирүүлдэг захидал нь нэг талаар мэдээллийн үүрэг гүйцэтгэж, нөгөө талаар нийтлэлийн шинэ санаа сэдэв өгч, зохион байгуулах ажлын үндэс болдог ач холбогдолтой юм. Энэ нь эцэстээ иргэд, хэвлэл мэдээллийн хэрэгсэл хоёр сэтгүүл зүйд хамтран зүтгэх тухай иргэний сэтгүүл зүйн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх нэг нөхцлийг бүрдүүлж байгаа юм. Эдгээрээс гадна сонин уншигчдын бага хурал, идэвхтэн бичигчдийн уулзалт семинар, ярилцлага зэрэг сонины газраас олон түмний дунд зохиох ажлын олон хэлбэр хувьсгалт сэтгүүл зүйн үед төлөвшин бүрэлдсэн билээ. Тэдгээрт арга барилын хувьд буруу зөрүү зүйл байсныг нуух хэрэггүй юм. Хамгийн гол нь хэвлэл мэдээллийн хэрэгслээс иргэдийн асуудалд онцгой анхаарал тавьж тусгах, тэдэнтэй ойр дөт хамтран ажиллах явдал манай сэтгүүл зүйд орхигдсон нь туйлын харамсалтай явдал.

Хэвлэл, олон түмэн хамтарч нийгмийн тулгамдсан болон сөрөг үзэгдлийг арилгаж өөрчлөн сайжруулах явдал гол агуулга нь болсон иргэний сэтгүүл зүй ардчиллын өлгий орон АНУ-д ч хүчтэй нэвтэрч байхад бид бэлэн байсан уламжлал туршлагаа гээж, иргэдээсээ улам бүр «зайгаа барьсаар» байгаа нь нэг янзын ухралт юм.

Монгол орны хувьд мэргэжлийн сэтгүүлч, хэвлэл мэдээллийн газрууд иргэний сэтгүүл зүйг тухайлан хөгжүүлэх оролдлого хийж байгаагүй боловч урсгал нийтлэлийн хэлбэрээр иргэний сэдэв байнга гарсаар ирсэн онцлогтой байна. Харин хэвлэл мэдээллийн газруудаас олон нийтийн үндсээ бэхжүүлэх зорилгоор зохиож ирсэн ажлын арга хэлбэрүүд нь бүхэлдээ иргэний сэтгүүл зүйн зохион байгуулах ажлын хэлбэртэй дүйж байгааг онцлон тэмдэглүүштэй юм.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн олон нийтийн үндэс суурь ихээхэн суларч, нийтлэл нэвтрүүлгийнх нь сэдэв агуулга олонх сонинд явцуурч, зарим талаар хэвлэл мэдээллийн үйл ажиллагааг үл ойшоох хандлага цухалзаж байгаа өнөө үед Иргэний сэтгүүл зүйг хөгжүүлэх, түүнд зориулсан тусгай хэвлэл гаргах, сэтгүүлчдийг мэргэжүүлэх, их сургууль, коллежийн сэтгүүл зйн сургалтын хөтөлбөрт иргэний сэтгүүл зүйг оруулах зэрэг бодитой ажил зохиох цаг нэгэнт болсон байна.